# Мөнгөн урамшуулалд хамрагдах хүсэлт илгээх заавар




Холбоос- [HTTPS://PLANT.MOFA.GOV.MN](https://plant.mofa.gov.mn)

Урамшууллын журамтай танилцах

# Урамшууллын хүсэлтээ хэзээ илгээх вэ ?

**1-р сар** — Нэгдүгээр сар

- Ибаримт бичих
- Гарал үүсэл авах

**2-р сар** — Дараа сарын 1-10 өдөр

- Урамшуулалд хамрагдах сар сонгох
- Данс оруулах
- Хүсэлт илгээх

**3-р сарын 15** — 45 хоног дотор

- Урамшууллын мөнгө олгогдох хугацаа

# Анхаарах зүйлс

Урамшууллын хүсэлт илгээхэд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Сумын агро нь тариаланчийг баталгаажуулсан байх
- Газрын мэдээлэл нь ГЗГЗЗГ-аас баталгаажсан байх
- Ибаримт Хүнсний ногооны урамшуулалтай гэсэн төрлөөр кг-аар бичигдсэн байх /Энд дарж заавар видео бичлэг үзэх/
- Гарал үүслийн гэрчилгээний хүчинтэй хугацаа нь тухайн сард харгалзах
- Урамшуулал хүлээн авах дансны мэдээлэл оруулах /Хүсэлт гаргагч ААН|Байгууллага зөвхөн өөрийн дансаа оруулах/
- Тухайн сард хүсэлтийг нэг удаа авах учир мэдээллээ сайн шалгаад "Хүсэлт“ өргөдөл хэсгийг сайн нягталж байж илгээнэ үү!

# 1. Тариаланчийн мэдээлэл баталгаажсан байх




**Алхам 1.**

-Тариаланч өөрийн эрхээр нэвтэрсэн байна.

-<u>Урамшууллын хүсэлт – Илгээх</u> цэс дээр дарж орно.

-Зурагт харагдаж байгаа шиг Анхааруулга гарч ирвэл та харьяа сумын “Хөдөө Аж Ахуйн Тасаг”-ийн мэргэжилтэнд хандаж бүртгэлээ баталгаажуулалт хийлгэх хэрэгтэй.

# 2. Урамшууллалд хамрагдах сар сонгох




**Алхам 2.**

-Урамшууллалд хамрагдах сар сонгоно. /Хүсэлт илгээх боломжтой сарууд нь идэвхтэй харагдаж байна. 7,8,9р сарууд./

-Зураг2 харагдаж байгаа анхааруулга гарсан бол та харьяа дүүрэг/сумын татварын байцаагч дээрээ очиж тариалан эрхэлдэг татвар төлөгчөөр Ибаримтын төсөл дээр бүртгүүлэх хэрэгтэй.

Доорх линк дээр дарж ибаримт үүсгэх заавартай танилцана уу!

№0.2 Ибаримт үүсгэх заавар видео.mp4 - Google Drive

# 3. Урамшуулалд хамрагдах сар сонгох үргэлжлэл




**Алхам 3.**

Урамшуулалд хармагдах сар сонгох үед ибаримтын систем дээр бүртгэгдсэн борлуулсан хүнсний ногоо, улаанбуудай байгаа эсэхийг лавлаж байгаа тул таны сонгосон сар дээр ибаримт бичигдээгүй бол дараах **Анхааруулга** гарч ирнэ.

# 4. Урамшуулалд хамрагдах тоо хэмжээ

99+ Баясгалан Батням

Урамшууллын хүсэлт / Урамшууллын хүсэлт илгээх

* Урамшуулалд хамрагдах сар: 2022-09

Ибаримт лавлах

| № | Урамшуулалд хамрагдах бүтээгдэхүүний код | Ибаримтаар баталгаажсан бүтээгдэхүүн | Тоо хэмжээ /кг/ |
|---|---|---|---|
| 1 | 0306007 | 1-р зэргийн хүнсний улаанбуудайн урамшуулал | 3 |
| 2 | 0709020 | Хэмх | 5 |
| 3 | 0709019 | Лооль | 10 |

| № | Таримал | ГҮГ авсан тоо хэмжээ | Урамшуулалд тооцуулсан тоо хэмжээ | ГҮГ-ний боломжит үлдэгдэл | Ибаримт бичигдсэн тоо хэмжээ | Урамшуулалд хамрагдах ГҮГ дүн оруулах |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Буудай | 14,849 кг | 3 кг | 14,846 кг | 3 кг | 3 |
| 2 | Буудай | 100 кг | 0 кг | 100 кг | 0 кг | 0 |
| 3 | Лооль | 1,000 кг | 10 кг | 990 кг | 10 кг | 10 |

Ибаримтын буцаан олголт авдаг данс сонгох: Тийм Үгүй

Хүсэлт гаргагч: Баясгалан овогтой Батням (УХ93080416)

Хүлээн авах дансны мэдээлэл: -

Урамшуулалд хамрагдах сар: 9 сар

**Ибаримт мэдээлэл амжилттай ирсэн**

Ибаримтын мэдээлэл ирсэн бол дараах байдлаар харагдаж байна.

**Алхам 4. Урамшуулалд хамраг бүтээгдэхүүний хэмжээ**

Таны урамшуулалд хамрагдах бүтээгдэхүүний “Гарал Үүслийн Гэрчилгээ - **ГҮГ**”-ийн хэмжээ ибаримт авсан бүтээгдэхүүний хэмжээтэй систем дээр харьцуулалт хийж аль багаар нь харуулж байна.

**Талбайн мэдээлэл Геодиз-ээр баталгаажсан байх**

Гарал үүслээ авсан ч зарим таримлын мэдээлэл орж ирэхгүй бол тариалалт хийсэн газрыг заавал баталгаажуулах хэрэгтэй. /Агрономчдоо хандах/

# 5. Дансны мэдээлэл оруулах




## Алхам 5. Дансны мэдээлэл оруулах

Хүсэлт гаргаж буй тариаланч нь ибаримтын буцаан олголт авдаг дансны бүртгэл бол **"ТИЙМ"** гэдгийг сонгоно. Хүсэлт гаргагчийн регистр дээр данс холбогдох данс байгаа бол таны данс бөглөгдөнө.

1. Байгууллага болон, ибаримтын буцаан олголт авдаггүй өөр дансандаа мөнгөн урамшууллаа авах бол **"ҮГҮЙ"** гэж сонгоод

**2.** Банк сонгох банкны нэр

**3.** Хүсэлт гаргагч өөрийн нэр дээрх дансны дугаарыг оруулаад (**4.**) **Шалгах** товч дээр дарах (**5.**) хэсэгт таны оруулсан дансны дугаар зөв бол хүлээн авагчийн нэр харагдана.

**6.** Урамшуулалд хамрагдах нийт хэмжээг нягтлах, хүсэлт хэсэгт харагдаж буй өргөдлийн утгыг хянаад (**7.**) "Хүсэлт илгээх" товч дээр дарснаар хүсэлт илгээгдэнэ.

# 6. Хүсэлтийн жагсаалт




**Алхам 6. Урамшууллын хүсэлт илгээгдсэн**

Таны хүсэлт амжилттай илгээгдсэн бол Урамшууллын хүсэлт – Хүсэлтийн жагсаалт цэс дээр таны хүсэлт “**Хүсэлт илгээсэн**” төлөвтэй “Улаанбуудай | Хүнсний ногоо” –оор салж илгээгдэнэ.

Төлөв дээр таны хүсэлтийг **Хүлээн авсан**, **Татгалзсан**, **Гүйлгээ хянагдаж , Олгогдсон, Данс нэр зөрсөн, Данс нэр засагдсан** гэсэн төлөвүүд “Төсвийн урамшууллын систем”-ээс солигдоно.

# Гарын авлага, заавар ашиглах




Системийн нүүр хуудас дээр “Гарын авлага, заавар” хэсэгт Систем ашиглах зааврын **ҮЗЭХ** дээр дарснаар шинэ цонх нээгдэх ба та өөрт тулгарсан асуудалд харгалзах заавstreet сонгож үзнэ үү.

